



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2019 оны 10 сарын 16 өдөр

Дугаар 4/640

Арвайхээр

Г

Г

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1 е, 29.2, Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6, 23.8, аймгийн Засаг даргын 2016 оны “Төсвийн сахилга, хариуцлагын тухай” 02 дугаар албан даалгаврыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн төсвийн орлогын төвлөрүүлэлтийг эрчимжүүлэх, төлөвлөгөөг биелүүлэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: И.Доржсүрэн –Аймгийн Засаг даргын орлогч
Гишүүд: Д.Нэмэхбаяр -аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн
сангийн хэлтсийн дарга

Н.Эрдэнэсувд -аймгийн Засаг даргын дэргэдэх Татварын хэлтсийн
дарга

М.Эрдэнэчuluун -аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн
хяналт, аудитын албаны даргын тур орлон
гүйцэтгэгч, улсын ахлах байцаагч

С.Цэдэнбалжир -аймгийн Засаг даргын дэргэдэх Хүнс, хөдөө аж
ахуйн газрын дарга

Ц.Алтан-Эрдэнэ –аймгийн Цагдаагийн газрын Замын цагдаагийн
тасгийн ахлах зохицуулагч, Цагдаагийн ахмад

Нарийн бичгийн дарга: Т.Эрдэнэсүрэн -аймгийн Засаг даргын Тамгын
газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн орлого
хариуцсан мэргэжилтэн

2. Төсвийн орлогын төвлөрүүлэлтийг эрчимжүүлэх, аймаг, сум орон нутгийн
орлогын төлөвлөгөөг бүрэн төвлөрүүлэх ажлыг удирдамжаар баталсугай.

3. Дээрх ажлыг хугацаанд нь чанартай, үр дүнтэй зохион байгуулахыг ажлын
хэсэг (И.Доржсүрэн)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г. ГАНБОЛД

011101193

Аймгийн Засаг дарын 2019 оны 10.
дугаар сарын 16...ны өдрийн 11.10 дугаар
захирамжийн хавсралт

**ТӨСВИЙН ОРЛОГЫН ТӨВЛӨРҮҮЛЭЛТИЙГ БҮРЭН
ТӨВЛӨРҮҮЛЭХ, ЭРЧИМЖҮҮЛЭХ АЖЛЫН УДИРДАМЖ**

Нэг.Зорилго:

2019 оны төсвийн орлогын дутуу төвлөрсөн аймгийн болон сумын орон нутгийн татварын орлогыг төвлөрүүлэхэд оршино.

Хоёр. Хамрах хүрээ:

Аймгийн бүх сумын албан байгууллага, аж ахуйн нэгж байгууллага, иргэн

Гурав. Төвлөрүүлэх орлогын төрөл:

Аймгийн төсөвт төвлөрүүлэх орлого

1. Цалин, хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого /Суутган/
2. Газрын төлбөр, дуудлага худалдаа
3. Хүү торгуулийн орлого /Цагдаагийн хүү торгууль, МХГ-ын хүү торгууль/
4. Бусад орлого /малжуулах сангаас олгосон зээл/

Орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлого

1. Үйл ажиллагааны орлого
2. Хөрөнгө борлуулсаны орлого
3. Бууны албан татвар
4. Улсын тэмдэгтийн хураамж
5. Ойн нөөцийн төлбөр
6. Ан агнуурын нөөц ашигласны төлбөр
7. Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр
8. Бусад орлого

Дөрөв. Дүгнэх

- Төсвийн орлогын төвлөрүүлэлтийг эрчимжүүлэх, орлогын төлөвлөгөөг нэр төрөл тус бүрээр төвлөрүүлэх ажлыг зохион байгуулж, сум, орон нутгийн төсвийн байгууллагын орлого хариуцсан мэргэжилтэн, татварын байцаагч нарыг татан оролцуулах, ажлын үр дүнг дүгнэж урамшуулах

- Аймаг, сумын орон нутгийн орлогын төлөвлөгөө тасарсан шалтгааныг тодруулж, холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцох зэрэг шат дараалсан арга хэмжээнүүдийг авч ажиллах

- Батлагдсан удирдамжийг хэрэгжүүлэх ажлын хэсэг ажлын үр дүн, тайланг 2019 оны 12 дугаар сарын 20-нд аймгийн Засаг даргад танилцуулах

Тав.Хугацаа

2019 оны 10 дугаар сарын 15-наас 12 дугаар сарын 15 хүртэл